



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Сургуулийн эргүүлийн ажиллах  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.1 дэх заалтыг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Төр, хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой "Сургуулийн эргүүл"-ийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.


2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Энхболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТТУЛГА



1110100533

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 10 сарын 16-ны  
өдрийн 177 дугаар тогтоолын хавсралт



## СУРГУУЛИЙН ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажилд сурагчдын эцэг эхийг татан оролцуулах замаар эргүүл зохион байгуулахад оршино.

1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйл "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах", 12.1.1 дэх хэсэг "Иргэдийг нийтийн эргүүлд гаргах" гэсэн заалтыг тус тус үндэслэн нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын улсын болон хувийн сургууль түүний орчинд сурагчдын эцэг эх /асрах хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийг эргүүлээр ажиллуулахад энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Сургуулийн орчинд "Сургуулийн эргүүлийн" үүрэг гүйцэтгэж байгаа иргэнд ажил олгогч байгууллага хагас өдрийн цалинтай чөлөө олгоно.

### Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал сургуулийн орчинд ажиллах "Сургуулийн эргүүл"-ийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж хяналт тавин, тасралтгүй явагдах нөхцлийг бүрдүүлж ажиллах ба тухайн сургуулийн жижүүр нь замын хөдөлгөөны аюулгүй байдлыг хангах талаар нэгдсэн ойлголт өгч ажиллана.

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн захирал тухайн хичээлийн жилд сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэх сурагчдын эцэг эх /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн хуваарийг гаргаж батлан эргүүлд ажиллах иргэдэд урьдчилан 7 хоногийн өмнө мэдэгдэнэ. Эргүүлийн хуваарийг хичээлийн өглөөний ээлж /07.30-13.30/ цаг, өдрийн ээлж /13.30-19.30/ цагт тус бүр 2 хүн гарахаар зохион байгуулна.

2.3. "Сургуулийн эргүүл" нь нэг удаад 4 эцэг эхийг эргүүлд гаргах бөгөөд 2 эргүүл замын хөдөлгөөны аюулгүй байдлыг хангаж ажиллах ба 2 эргүүл нь сургуулийн ойр орчимд хөдөлгөөнт эргүүлийн үүргийг тус тус гүйцэтгэнэ.

2.4. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага сургуулийн удирдлага, эргүүлд ажиллаж байгаа сурагчдын эцэг эх /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д мэргэжил, аргазүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэлд шуурхай үүрэг гүйцэтгэж ажиллана.



2.5 "Сургуулийн эргүүл"-ийг амжилттай хэрэгжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан сургуулийн захирал, нийгмийн ажилтан, ангийн багш, эцэг эхийн эргүүлийг монголын сурагчдын холбооны дэргэдэх "Сургуулийн цагдаа" төвд санал, мэдээлэл, тайланг үндэслэн төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс /дурсгалын зүйл/ урамшуулна.

2.6 Тухайн сургууль "Сургуулийн эргүүл"-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хантааз, станц, дохиурыг Сурагчдын холбооны дэргэдэх "Сургуулийн эргүүл" төвд албан бичгээр хүсэлтээ хүргэж үнэ төлбөргүй авч эргүүлэн тушаана.

### **Гурав. Эргүүлийн үйл ажиллагаа, тавигдах шаардлага, хориглох зүйл**

3.1. Сургууль болон түүний орчинд ажиллах "Сургуулийн эргүүл"-д 18 насанд хүрсэн, согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглээгүй, сэтгэцийн өвчингүй, эргүүлийн үүрэг гүйцэтгэх эрүүл мэндийн чадвартай сурагчдын эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг урьдчилан гаргасан хуваарийн дагуу ажиллуулна.

3.2. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх эцэг эх, асран хамгаалагч энэхүү журамтай урьдчилан танилцаж сургуулийн нийгмийн ажилтан, жижүүр багшаас зааварчилгаа авч "Сургуулийн эргүүл" гэсэн хантаазийг өмсөж эргүүлд ажиллана.

3.3. Эргүүлд ажиллаж байгаа эцэг эх, асран хамгаалагч тухайн сургуулийн жижүүр дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

а/ Гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг Сурагчдын холбооны дэргэдэх "Сургуулийн эргүүл" төвийн тусгай дугаарт /322112/ болон Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

б/ Сургуулийн бүсэд сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ.

в/ Хичээл орох болон тарах цагуудад сурагчдыг сургуулийн орчинд байгаа /сургуулийн бүсэд хамаарах/ замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход дэмжлэг үзүүлнэ.

г/ Хичээлийн завсарлагаанаар сургуулийн орчинд болон сургууль дотор эргүүлийн үүрэг гүйцэтгэж Монгол Улсын хууль тогтоомж болон сургуулийн дүрэм журмыг мөрдөх талаар шаардлага тавьж ажиллана.

д/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн зүгээс болон Хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд идэвхитэй оролцоно.

е/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд сургуулийн орчинд гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тохиолдолд мэдээллийг цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлнэ.

ё/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэгтэх хугацаанд “Сургуулийн эргүүл” хантаазийг бохирдуулж, гэмтээхгүй өмсөж хэрэглэж эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаа дуусахад ажилласан талаарх илтгэх хуудсыг бичиж хантаазын хамт сургуулийн нийгмийн ажилтан болон жижүүр багшид өгнө.

3.4. Эргүүлд ажиллаж байгаа эцэг эх, асран хамгаалагч үүрэг гүйцэтгэх хугацаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж иргэд, хүүхдүүдтэй зөв боловсон харьцах ба төрийн байгууллагын ажилтны нэр барьж хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.5. “Сургуулийн эргүүл”-д ажиллах эцэг эх, асран хамгаалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслахыг хориглох бөгөөд хэрэв хуваарийн дагуу эргүүлд ажиллах боломжгүй болсон тохиолдолд энэ талаар сургуулийн удирдлагад 3 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

#### **Дөрөв.Бусад зүйл, хариуцлага**

4.1. Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эцэг эх, асран хамгаалагч үүрэг гүйцэтгэж байх хугацаанд халдлагад өртсөн тохиолдолд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн /22-р зүйлийн/ холбогдох заалтын дагуу төрөөс хохиролыг барагдуулна.

4.2. Эргүүлийн үүрэг гүйцэтгэхээс санаатай зайлсхийсэн тохиолдолд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт /Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ бүх нийтээр дагаж мөрдүүлэхээр хууль тогтоомжийн дагуу гаргасан шийдвэрийг зөрчсөн бол/ заасны дагуу арга хэмжээ ногдуулна.

